



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/33/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн дарга, аудитын менежер Х.Түвшинбаяр Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn Аудитын менежер Д.Отгонбаяр Утас: 325093 Цахим хаяг: otgonbayard@audit.gov.mn Ахлах аудитор: Н.Бадамхатан Утас: 325093 Цахим хаяг: badamkhatann@audit.gov.mn Аудитор: М.Нарангэрэл Утас: 325093 Цахим хаяг: narangerelm@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

 ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР	НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА А.СЭРЭЭТЭР ТАНАА
<p>14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар, Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54, И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn</p>	
<p>2024.02.23 № 315 танай _____-ны № _____-т</p>	
АУДИТЫН ДҮГНЭЛТ	
Хязгаарлалттай дүгнэлт	
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p>	
<p>Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p>	
Дүгнэлтийн үндэслэл	
<p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p>	
<p>Төсвийн шууд захирагчийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 832,033.6 мянган төгрөгийн залруулаагүй алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.</p>	
Асуудлыг онцолсон хэсэг	
<p>Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.</p>	
Аудитын гол асуудал	
<p>Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.</p>	
Бусад асуудлын хэсэг	

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 68 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 92.6 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.,

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.Аудит хийсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Эргэлтийн хөрөнгийн дүн	2,266,744,303.49	2,775,629,767.62
33	Авлага	2,266,744,303.49	2,775,629,767.62
33700	Хөтөлбөртэй холбоотой авлага	2,190,312,143.49	2,323,127,907.62
33703	Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих	1,220,538,844.49	1,285,520,919.49
33705	Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих	425,760,700.00	435,363,330.00
33717	Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ	248,394,000.00	318,795,059.13
33718	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих	295,618,599.00	283,448,599.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	76,432,160.00	452,501,860.00
2	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	-
3	Нийт хөрөнгийн дүн III=I+II	2,266,744,303.49	2,775,629,767.62
5	Цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,266,744,303.49	2,775,629,767.62
51	Засгийн газрын хувь оролцоо	2,266,744,303.49	2,775,629,767.62
51200	Хуримтлагдсан үр дүн	2,266,744,303.49	2,775,629,767.62
51210	Өмнөх үеийн үр дүн	2,235,655,656.40	2,190,312,143.49
51220	Тайлант үеийн үр дүн	31,088,647.09	585,317,624.13
6	Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн VI=IV+V	2,266,744,303.49	2,775,629,767.62

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үйл ажиллагааны орлогын дүн (I)	2,297,327,960.00	2,259,687,800.00
12	Татварын бус орлого	304,825,960.00	401,007,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	304,825,960.00	401,007,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	304,825,960.00	401,007,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	304,825,960.00	401,007,800.00
13	Тусламж, санхүүжилтийн орлого	1,992,502,000.00	1,858,680,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		1,858,680,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих		1,858,680,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,992,502,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,992,502,000.00	-
2	Үйл ажиллагааны зардлын дүн	2,266,239,312.91	1,674,370,175.87
21	Урсгал зардал	2,266,239,312.91	1,674,370,175.87
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	4,500,000.00	66,382,850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,500,000.00	66,382,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,500,000.00	66,382,850.00
213	Урсгал шилжүүлэг	2,261,739,312.91	1,607,987,325.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	714,105,040.00	621,566,290.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	714,105,040.00	621,566,290.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	245,732,800.00	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	245,732,800.00	-
2134	ОНТ-ийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас	-	309,157,800.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	309,157,800.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт	1,301,901,472.91	677,263,235.87
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,301,901,472.91	677,263,235.87
3	Үйл ажиллагааны үр дүн (3)=(1)-(2)	31,088,647.09	585,317,624.13
5	Нийт үр дүн (5)=(3)+(4)	31,088,647.09	585,317,624.13

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн(1)	2,763,966,671.91	2,259,687,800.00
12	Татварын бус орлого	771,464,671.91	401,007,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	771,464,671.91	401,007,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	771,464,671.91	401,007,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	304,825,960.00	401,007,800.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	466,638,711.91	-
13	Тусламж, санхүүжилтийн орлого	1,992,502,000.00	1,858,680,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	1,858,680,000.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	-	1,858,680,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,992,502,000.00	-
131104	Дээд шатны ТЗ-ийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,992,502,000.00	-
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн (2)	3,200,671,472.91	2,961,372,035.87
21	Урсгал зардал	3,200,671,472.91	2,961,372,035.87
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	4,500,000.00	66,382,850.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4,500,000.00	66,382,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,500,000.00	66,382,850.00
213	Урсгал шилжүүлэг	3,196,171,472.91	2,894,989,185.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,572,105,040.00	1,456,066,290.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,572,105,040.00	1,456,066,290.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	322,164,960.00	360,651,860.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	322,164,960.00	360,651,860.00
2134	ОНТ-ийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	401,007,800.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	401,007,800.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт	1,301,901,472.91	677,263,235.87
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,301,901,472.91	677,263,235.87
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ (3)=(1)-(2)	(436,704,801.00)	(701,684,235.87)
14	Бусад эх үүсвэр	436,704,801.00	701,684,235.87
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	436,704,801.00	701,684,235.87
7	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	436,704,801.00	701,684,235.87
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	436,704,801.00	701,684,235.87
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	2,266,744,303.49	2,266,744,303.49
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,266,744,303.49	2,266,744,303.49
C08	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,266,744,303.49	2,266,744,303.49
D01	2023 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	2,266,744,303.49	2,266,744,303.49
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(76,432,160.00)	(76,432,160.00)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,190,312,143.49	2,190,312,143.49
D08	Тайлант үеийн үр дүн	585,317,624.13	585,317,624.13
D09	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,775,629,767.62	2,775,629,767.62

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

(төгрөг)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1,858,680,000.00	1,522,449,140.00	336,230,860.00	81.9
21	Урсгал зардал	1,858,680,000.00	1,522,449,140.00	336,230,860.00	81.9
210	Бараа,ажил үйлчилгээний зардал	71,750,000.00	66,382,850.00	5,367,150.00	92.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	71,750,000.00	66,382,850.00	5,367,150.00	92.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	71,750,000.00	66,382,850.00	5,367,150.00	92.5
213	Урсгал шилжүүлэг	1,786,930,000.00	1,456,066,290.00	330,863,710.00	81.5
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,786,930,000.00	1,456,066,290.00	330,863,710.00	81.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж	1,786,930,000.00	1,456,066,290.00	330,863,710.00	81.5
1310	Улсын төсвөөс	1,858,680,000.00	1,522,449,140.00	336,230,860.00	81.9
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	1,858,680,000.00	1,522,449,140.00	336,230,860.00	81.9

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой 611,943.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав.

Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

(мянган төгрөг)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Авлагыг бууруулж тайлагнасан.	1	611,943.9			1	611,943.9	1	611,943.9		
Дүн	1	611,943.9			1	611,943.9	1	611,943.9		

Аудитаар нийт 832,033.6 мянган төгрөгийн зөрчил² илэрч 8,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 824,033.6 мянган төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд олгосон санхүүгийн дэмжлэгийг зориулалт бусаар зарцуулсан.	1	8,000.0	1	8,000.0				
Батлан даагчийн шаардлага хангаагүй 5 төслийг сонгон шалгаруулсан.	1	35,000.0					1	35,000.0
Төсөлд тавигдах үндсэн шаардлагыг нотлох баримтаар хангаагүй төслийг сонгон шалгаруулсан.	1	34,000.0					1	34,000.0
Тайлант онд баримтын бүрдэл дутуу төслийг сонгон шалгаруулсан.	1	101,000.0					1	101,000.0
Тайлант онд олгосон хугацаа хэтэрсэн зээлд алданги тооцоогүй.	1	27,621.0					1	27,621.0
Зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн авлагын үлдэгдэл нь тусгай сангийн үйл ажиллагааг үр ашиггүй болгох нөхцөлийг үүсгэх эрсдэлтэй бөгөөд тооцооны үлдэгдлийн баталгааг төсөл хэрэгжүүлэгч нартай бүрэн гүйцэт нийлээгүй.	1	626,412.6					1	626,412.6
Дүн	6	832,033.6	1	8,000.0			5	824,033.6

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.